



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 653

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, нийт 20,634,763.50 (хорин сая зургаан зуун гучин дөрвөн мянга долоон зуун жаран гурван төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины (мотоцикл, трактор) 2 дахь удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ГАВАА

0002721

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
653 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИНЫ ЖАГААЛАЛТ

Д/д	Автомашини нэр, марк, улсын бүртгэлийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуриятлагдсан эзлэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг)
1. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны эргүүл, хамгаалалтын газар								
1	Мотоцикл, 80-14 УБ, (арал-20000774, иж планета)	2002	8888	1,558,453.50	1,558,453.50	1,558,453.50	-	50,000.00
2	Мотоцикл, 80-15 УБ, (арал-4gw162mj, хүлэг)	2005	6707	1,176,310.00	1,176,310.00	1,176,310.00	-	50,000.00
3	Мотоцикл, 00-05 ЭХГ (хука0970m69075, иж)	2008	5421	1,300,000.00	1,300,000.00	1,300,000.00	-	50,000.00
	Дүн				4,034,763.50	4,034,763.50	-	150,000.00
2. "Сүүж-Уул" сэргээн засах амралт, сувилал								
4	Трактор (бага оврын)	2007	12800	2,000,000.00	2,000,000.00	2,000,000.00	-	300,000.00
	Дүн			2,000,000.00	2,000,000.00	2,000,000.00	-	300,000.00
3. Дотоодын цэргийн 05 дугаар анги								
5	УАЗ 2206 фургон, 76-52	2008	331547	14,600,000.00	14,600,000.00	14,600,000.00	-	200,000.00
	Дүн			14,600,000.00	14,600,000.00	14,600,000.00	-	200,000.00
	Нийт дүн				20,634,763.50	20,634,763.50	-	650,000.00 (зургаан зуун тавин мянган)